

“ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ.

Хүнсний аюулгүй байдлыг хангах асуудал нь салбарын төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, мөн судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагаа, ажлын уялдаа, хувийн хэвшлийн санаачилга, идэвхтэй оролцоог шаардсан салбар дундын зохицуулалтын шинжтэй, бүх нийтийг хамарсан чухал ач холбогдолтой.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас “Дэлхийн хүнсний өдөр”-ийг 1981 оноос жил бүрийн 10 дугаар сарын 16-нд тэмдэглэж ирсэн.

Энэ өдрийг тохиолдуулан уламжлал болгон зарласан “Хүнсний аюулгүй байдал” эрдэм шинжилгээний бага хурлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, Монголын хүнсчдийн холбоо хамтран Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хурлын их танхимд 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр 08.30-17.30 цагт зохион байгууллаа.

Хурлыг нээж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулга, Монголын хүнсчдийн холбооны гүйцэтгэх захирал М.Говьсайхан, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын төслийн зохицуулагч Б.Алтанцэцэг нар үг хэлэв.

Бага хурлыг Дэлхийн хүнсний өдрөөр уламжлал болгон жил бүр зохион байгуулснаар дараах ач холбогдолтой. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлыг хангахад оюутан, судлаач, эрдэм шинжилгээний ажилтны оруулах хувь нэмрийг зохих ёсоор үнэлэх;
- Эрдэм шинжилгээ, судалгааны дүнг төрийн бодлого, шийдвэрт тусган хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх;
- Төрийн захиргааны болон эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх;
- Хүнсний салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, олон нийтэд сурталчлан таниулах;
- Хүнсний салбарын боловсон хүчнийг бодлогын түвшинд бэлтгэх, салбар дундын уялдааг хангах.

Хурлын эхэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан, зөвлөх инженер, шинжлэх ухааны доктор, профессор Л.Дамдинсүрэн “Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд” сэдвээр хүндэтгэлийн илтгэл тавилаа. Хүндэт илтгэгчийн өргөмжлөл, шагналыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Т.Гантогтох гардуулав.

“Хүнсний аюулгүй байдал-2017” бага хуралд оюутан, судлаачийн ангилалд Хөдөө аж ахуйн их сургууль, харьяа хүрээлэнгүүд, Дархан дахь салбар сургууль, Шинжлэх Ухааны Академийн Хими, хими технологийн хүрээлэн, Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, мөн Дорноговь аймаг дахь салбар, “Идэр” их сургууль, Хүнсний технологийн дээд сургуулиас нийт 33 илтгэл ирүүлсэн. Илтгэлийг эхний шатанд төрийн, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг хянан үзсэн бөгөөд хянан үзэх шатанд шалгарсан илтгэлүүдийг хэлэлцүүлсэн. Үүнд:

Бакалаврын оюутны түвшинд:

№	Илтгэл	Илтгэгч
1	Шар сүүгээр цэлцэгнүүр хийх технологийн судалгаа	ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн оюутан С.Анхчимэг
2	Шар буурцаганы шим тэжээллэг чанарыг бусад бүтээгдэхүүний шинж чанартай харьцуулсан судалгааны дүнгээс	ШУТИС-ийн Үйлдвэрлэл, технологийн сургуулийн оюутан О.Мөнхзул, Б.Ууганцэцэг
3	Ундаан дахь тартразины агуулгыг тодорхойлох	МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургуулийн оюутан М.Отгон-Үжсин
4	Байгалийн зэрлэг аньс, нэрс жимсэнд формальдегид тодорхойлсон дүнгээс	АШУУИС-ийн Био анагаахын сургуулийн оюутан Ч.Алтаншагай
5	Импортын зарим нэр төрлийн шоколадны шошгололтын байдалд хийсэн тандалт судалгаа	“Идэр” их сургуулийн оюутан Д.Ичинхорлоо
6	Д аминдэмээр баялаг хоолны цэсний зохиомж	ШУТИС-ийн Үйлдвэрлэл, технологийн сургуулийн оюутан Ш.Эрхэмбаяр
7	Хүнсний хаягдал материалаас экологид ээлтэй шинэ бүтээгдэхүүн гарган авах боломжийн судалгаа	ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн оюутан Ц.Бат-Эрдэнэ
8	Улаан лоолийг хадгалах явцад үүсэх бичил биетний бохирдолтын судалгаа	ШУТИС-ийн Үйлдвэрлэл, технологийн сургуулийн оюутан М.Пүрэвдулам, Г.Нандин-Эрдэнэ
9	Хүчиллэг орчинд β-лактоглобулин уургийн утаслаг үүсэх кинетик судалгаа	МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургуулийн оюутан С.Сэлэнгэсүрэн, А.Номунгоо
10	Хоолны давсны иодын агууламжийн судалгаа	ШУТИС-ийн Үйлдвэрлэл, технологийн сургуулийн оюутан Б.Ундрам

Судлаачийн хэмжээнд:

№	Илтгэл	Илтгэгч
1	Зохицуулах үйлчилгээтэй инулины хэрэглээ, үйлдвэрлэх боломж	ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Б.Баярмаа
2	Монгол орны мал, амьтдад тархсан хянахад төвөгтэй халдварт өвчнүүдийн молекул эпидемиологийн судалгаа	ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуулийн багш, доктор Н.Очирхүү
3	Ерөнхий боловсролын сургууль, түүний орчинд борлуулагдаж буй хоол хүнсний тэжээллэг чанарын судалгаа	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Түвшинбаяр
4	Зарим хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын судалгаа	ХААИС-ийн Мал эмнэлгийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Б.Нарангэрэл
5	Хүн амын хүнсний хэрэглээг удирдахуй	ШУТИС-ийн Үйлдвэрлэл, технологийн сургуулийн багш, доктор Ц.Одбаяр

6	Пробиотик бэлдмэлийн технологийн судалгаа	<i>Хүнсний технологийн дээд сургуулийн багш Ц.Доржсүрэн</i>
7	Хатуу буудайн гурилаар зөөлөн буудайн чанарыг сайжруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж	<i>ХААИС-ийн Дархан дахь Агрэкологич бизнесийн сургуулийн багш Ц.Сансаргэрэл</i>
8	Хоол зүйн маргаантай асуудлуудын шийдэл	<i>ШУТИС-ийн Үйлдвэрлэл, технологийн сургуулийн багш, шинжлэх ухааны доктор Г.Лхагваа</i>
9	Хүнсний коллаген уургийг Монгол Улсад үйлдвэрлэх боломж	<i>ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Мөнхцэцэг</i>
10	Хонины гурван шимт яснаас эрдсийн бэлдмэл үйлдвэрлэх технологийн судалгаа	<i>Хүнсний технологийн дээд сургуулийн багш, доктор Н.Чимэгээ</i>

Хуралд амжилттай оролцож илтгэл нь шалгарсан дараах оюутан, судлаачдыг ХХААХҮ-ийн сайдын үүрэг гүйцэтгэгч П.Сэргэлэн батламж, өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулав.

ОЮУТАН		
Тэргүүн байр	ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн оюутан Ц.Бат-Эрдэнэ	<i>Хүнсний хаягдал материалаас экологид ээлтэй шинэ бүтээгдэхүүн гарган авах боломжийн судалгаа</i>
Дэд байр	МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургуулийн оюутан М.Отгон-Үжин, А.Номин	<i>Ундаан дахь тартразины агуулгыг тодорхойлох</i>
Тусгай байр	МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургуулийн оюутан С.Сэлэнгэсүрэн	<i>Хүчиллэг орчинд β-лактоглобулин уургийн утаслаг үүсэх кинетик судалгаа</i>
СУДЛААЧ		
Тэргүүн байр	ШУТИС-ийн Үйлдвэрлэл, технологийн сургуулийн багш, шинжлэх ухааны доктор Г.Лхагваа	<i>Хоол зүйн маргаантай асуудлуудын шийдэл</i>
Дэд байр	ШУТИС-ийн Үйлдвэрлэл, технологийн сургуулийн багш, доктор Ц.Одбаяр	<i>Хүн амын хүнсний хэрэглээг удирдахуй</i>
Тусгай байр	ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуулийн багш, доктор Н.Очирхүү	<i>Монгол орны мал, амьтдад тархсан хянахад төвөгтэй халдварт өвчнүүдийн молекул эпидемиологийн судалгаа</i>

Бага хуралд амжилттай оролцож, тэргүүн, дэд, тусгай байрт шалгарсан оюутан, судлаачдад Монголын хүнсчдийн холбооны менежер Д.Цэцэнбилэг хүнсний үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний дээжийг гардуулав. Мөн “Жүр үр” ХХК-иас нэрэмжит шагналаа “Хатуу буудайн гурилаар зөөлөн буудайн чанарыг сайжруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж” сэдвээр илтгэсэн ХААИС-ийн Дархан дахь Агрэкологич бизнесийн сургуулийн багш Ц.Сансаргэрэлд олголоо.

Хурлыг өндөрлүүлж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч П.Сэргэлэн үг хэлэв. Тэрээр Монголын хүнсчдийн холбоо, түүний гишүүн байгууллагууд, хүнсний үйлдвэрүүд дараа жилээс тус бага хуралд амжилттай оролцсон оюутнуудыг үйлдвэрлэлийн дадлага хийх нөхцөл бүрдүүлэх, ажлын байраар хангах, сургалтын төлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх зэрэг үнэтэй санал, санаачилга гаргасанд талархал илэрхийлэв.

Бага хурлын илтгэлүүдийг эмхэтгэл болгон жил бүр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын санхүүжилтээр хэвлүүлж байх юм.

Хурлын төгсгөлд 2018 онд Дэлхийн хүнсний өдрөөр зохион байгуулах бага хурлын сэдвийг зарласан. Ирэх жил тус бага хурлыг **“Хүнсний аюулгүй байдал: хүнсний экспорт”** сэдвийн хүрээнд зохион байгуулна. Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, оюутан, багш, эрдэмтэн, судлаачид дээрх сэдвийн хүрээнд судалгаагаа чиглүүлж, ирэх жил тус бага хуралд оролцохыг урьж байна.